



ДИ БИ ЭМ АССЕТ МЕНЕЖМЕНТ УЦК ХХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ШИЙДВЭР

2022 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот


“Ди Би Эм ассет менежмент УЦК” ХХК-ийн
талаар авах зарим арга хэмжээний тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.2.11, 62.2.12 дахь заалт, компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1.14, 8.1.15 дахь заалтыг тус тус үндэслэн ШИЙДВЭРЛЭХ нь:

1. “Ди Би Эм ассет менежмент УЦК” ХХК-ийн “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг шийдвэрийн хавсралтаар баталсугай.
2. Энэхүү журмыг үйл ажиллагаандaa мөрдөж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.



МОНГОЛ УДСЫН ХӨГЖЛИЙН БАНКНЫ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Н.МАНДУУЛ



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

Баримтын хувилбар 2.0

Огноо/.... /....

Журмын код:




Компанийн дотоод хэрэгцээнд ашиглана.

Хамрах хүрээ: “Ди Би Эм ассет менежмент УЦК” ХХК	Журмын код:
Хариуцах эзэн: ТУЗ-ын Нарийн Бичгийн Дарга	Танилцах: ТУЗ, ТУЗНБД, Компанийн эрх бүхий этгээд
Баталсан огноо: 2022/04/21	Хуудас 2 /30

**БАРИМТ БИЧИГТ ОРСОН ӨӨРЧЛӨЛТҮҮД
ЖУРМЫГ БАТАЛСАН:**

ОГНОО	ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД	
2022/04/21	Хувьцаа эзэмшигчийн шийдвэр	02

ЖУРМЫГ ХЯНАСАН:

ОГНОО	ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД	Гарын үсэг
2022/02/20	Д.Мөнхбат (Гүйцэтгэх захирал)	
2022/02/15	М.Жавхлан (Сангийн менежер)	
2022/02/15	Ш. Мөнхцэцэг (Захиргаа, хүний нөөцийн ахлах мэргэжилтэн)	

ЖУРМЫГ БОЛОВСРУУЛСАН:

ХУВИЛБАР №	ОГНОО	АЖИЛТАН	ТАЙЛБАР
1.0	2017/08/20	Ш.Мөнхцэцэг Ш.Түмэнбаяр	МУХБ-ны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017.08.23-ны өдрийн 69 дүгээр тогтоолоор баталсан.
1.1	2018/04/02	Б.Мөнхдэлгэр	Шинэчилсэн найруулгын төслийг бэлтгэсэн бөгөөд батлуулаагүй төсөл байна.
2.0	202/12/21	Д.Нэрэнцогт (Хуулийн зөвлөх)	2021.11.23-ны шинэчилсэн Компанийн дүрмийн өөрчилөлттэй уялдуулан өөрчилөв.

Хамрах хүрээ: “Ди Би Эм ассет менежмент УЦК” ХХК	Журмын код:
Хариуцах эзэн: ТУЗ-ын Нарийн Бичгийн Дарга	Танилцах: ТУЗ, ТУЗНБД, Компанийн эрх бүхий этгээд
Баталсан огноо: 2022/04/21	Хуудас 3 /30

АГУУЛГА

- НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ.
- ХОЁР. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭН ЭРХ.
- ГУРАВ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН.
- ДӨРӨВ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭН ЭРХИЙН ХУГАЦАА.
- ТАВ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШҮҮЛЭХ, НЭР ДЭВШИГЧИЙГ ЖАГСААЛТАД БҮРТГЭХ, СОНГОХ ЖУРАМ.
- ЗУРГАА. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА.
- ДОЛОО. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛ.
- НАЙМ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ.
- ЕС. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА.
- АРАВ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭ.
- АРВАН НЭГ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА.
- ХАВСРАЛТ 01. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНД НЭРДЭВШИГЧИЙН ЗӨВШӨӨРӨЛ, БАТЛАМЖИЙН ЗАГВАР.
- ХАВСРАЛТ 02. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛД НЭР ДЭВШИГЧИЙН АНКЕТ АНКЕТИЙН ЗАГВАР.
- ХАВСРАЛТ 03. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛЫН ЗАГВАР.
- ХАВСРАЛТ 04. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛИЙН ЗАГВАР.
- ХАВСРАЛТ 05. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДЭД ТОВ ХҮРГЭХ ТУХАЙ АЛБАН БИЧГИЙН БОЛОН ХӨТӨЛБӨРИЙН ЗАГВАР.
- ХАВСРАЛТ 06. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.

Хамрах хүрээ: "Ди Би Эм ассет менежмент УЦК" ХХК	Журмын код:
Хариуцах эзэн: ТУЗ-ын Нарийн Бичгийн Дарга	Танилцах: ТУЗ, ТУЗНБД, Компанийн эрх бүхий этгээд
Баталсан огноо: 2022/04/21	Хуудас 4 /30

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү журмын дагуу Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид "ТУЗ" гэх)-ийн бүрэн эрх, түүний гишүүдийн эрх, үүрэг, хариуцлага, бүрэлдэхүүн, ТУЗ-ийн гишүүд (цаашид "Гишүүн" гэх)-ийг нэр дэвшижүүлэх, сонгох журам, ТУЗ-өөс компанийн бусад эрх бүхий этгээд, гүйцэтгэх удирдлагатай харилцах харилцаа, мөн бүрэн эрхийн хугацаа дусахаас өмнө гишүүнийг чөлөөлөх, ТУЗ-ийн хуралд бэлдэх, зарлах, хуралдуулах журам зэрэг үйл ажиллагааг зохицуулна.

ХОЁР. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭН ЭРХ

- 2.1 ТУЗ-өөс МУ-ын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, компанийн хүчин төгөлдөр дүрмийн дагуу хувьцаа эзэмшигчдийн хурал (ХЭХ)-ын бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэх асуудлаас бусад компанийн гүйцэтгэх удирдлага, компанийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- 2.2 Компанид хадгалж байвал зохих нэмэлт баримт бичгийн жагсаалт гаргах;
- 2.3 ХЭХ-д бэлтгэх, хурлыг зохион байгуулахтай холбоотой ТУЗ-ийн бүрэн эрх дараах үйл ажиллагааг хамаарна. Үүнд:
- 2.3.1 Хувьцаа эзэмшигчийн ээлжит хурал (ХЭЭХ) болон хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал (ХЭЭБХ)-ыг зарлах;
 - 2.3.2 Хувьцаа эзэмшигчийн ХЭХ-ын хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулахаар гаргасан саналыг хүлээн авч, хуулийн дагуу хянан үзэх;
 - 2.3.3 Хувьцаа эзэмшигч нь тодорхой асуудлыг хэлэлцүүлэхээр санал болгосон эсэхээс үл хамааран өөр бусад асуудлыг ХЭХ-ын хэлэлцэх асуудлуудад тусгах;
 - 2.3.4 ХЭХ-ын хэлэлцэх асуудлуудыг батлах, хувьцаа эзэмшигчийн саналыг хурлын хэлэлцэх асуудалд тусгах;
 - 2.3.5 ХЭХ хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчид мэдэгдэх өдөр, журмыг тодорхойлох;
 - 2.3.6 ХЭХ-д бэлтгэх явцад хувьцаа эзэмшигчийн танилцаж болох мэдээллийн (материал) жагсаалт гаргах, тухайн мэдээлэлтэй танилцах боломжоор хангах;
 - 2.3.7 Хэрэв саналын хуудсаар урьдчилан санал авах тохиолдолд ХЭХ болох огноо, газар, эхлэх цаг, бөглөсөн саналын хуудсаа илгээх шуудангийн хаягийг тодорхойлох, саналын хуудсыг хүлээн авах сүүлчийн өдрийг тодорхойлох;
 - 2.3.8 Саналын хуудсаар санал авах бол саналын хуудасны маягт, агуулгыг батлах;
 - 2.3.9 Дараах тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлана. Үүнд:
 - i. Компанийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1, 61.7 дах хэсэгт заасны дагуу;
 - ii. Хэрэв компанийн ХЭХ хуульд заасны дагуу ТУЗ-д хараат бус гишүүнийг сонгоогүй, эсвэл хараат бус гишүүн нь хуульд заасан хараат бус байдлаа алдсан;

Хамрах хүрээ: “Ди Би Эм ассет менежмент УЦК” ХХК	Журмын код:
Хариуцах эзэн: ТУЗ-ын Нарийн Бичгийн Дарга	Танилцах: ТУЗ, ТУЗНБД, Компанийн эрх бүхий этгээд
Баталсан огноо: 2022/04/21	Хуудас 5 /30

2.3.10 ХЭЭБХ-ыг хуралдуулах саналыг авч үзэх, хурал зарлах хүсэлт хүлээн авсны дараа ажлын арван (10) хоногийн дотор ХЭЭБХ-ыг хуралдуулах эсэх талаар шийдвэр гаргах;

2.3.11 ХЭЭБХ-ыг зарлах, зарлахаас татгалзсан шийдвэрийг сонирхсон талуудад нэн даруй мэдэгдэх;

2.3.12 Компанийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэгт зохицуулсны дагуу ХЭЭБХ хийх тухай мэдэгдэл гаргасан өдрөөс эхлэн хувьцаа эзэмшигчдэд хэлэлцэх асуудалтай холбогдох баримт бичигтэй танилцах боломжоор хангана.

2.3.13 Компанийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.4-т заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах тухай энэхүү журмын 2.3.10-т заасан шийдвэр гаргасан тохиолдолд санал, шаардлага хүлээн авсан өдрөөс хойш 45(дөчин тав) хоногийн дотор тухайн хурлыг хуралдуулна.

2.4 Компанийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.
Үүнд:

2.4.1 үүсгэн байгуулахаар төлөвлөж буй хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгө оруулалтын бодлогын төслийг хэлэлцэж батлах;

2.4.2 хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгө итгэмжлэн удирдах журмыг батлах;

2.4.3 хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэхтэй холбоотой судалгаа хийх аргачлалыг баталж, түүний дагуу гаргасан дүгнэлт, зөвлөмжийг хянах тогтолцоог бүрдүүлэх зэргээр гүйцэтгэх удирдлагын зүгээс хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгөөр хийх хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг удирдамжаар хангах, гэрээнд заасан бол дүгнэлт гаргах;

2.4.4 хөрөнгө оруулалтын менежментийн гэрээний төслийг батлах;

2.4.5 шинээр хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах эсэх асуудлаар дүгнэлт гаргах;

2.4.6 шинээр хөрөнгө оруулалтын сан байгуулахтай холбогдон хувьцаа нэмж гаргах эсэх асуудлаар дүгнэлт гаргах;

2.4.7 удирдаж байгаа болон гэрээний дагуу үйлчилгээ үзүүлж байгаа хөрөнгө оруулалтын сантай байгуулсан гэрээний биелэлтийн талаар гүйцэтгэх удирдлагын тайланг сонсож, дүгнэлт өгөх;

2.5 Компанийн үнэт цаас, үндсэн хөрөнгөтэй холбоотой ТУЗ-ийн бүрэн эрх дараах үйл ажиллагааг хамаарна. Үүнд:

2.5.1 энгийн хувьцаа, давуу эрхтэй хувьцаа, өрийн бичиг, опцион гэх мэт үнэт цаасанд хөрвөх чадвартай хувьцааг гаргах талаар шийдвэр гаргах;

2.5.2 үндсэн хөрөнгийн үнэлгээг тогтоох, гаргах үнэт цаасны төрөл, тоо, гаргах хугацаа, нөхцөлийг тогтоох;

2.5.3 ногдол ашгийн төлбөрийн хэмжээг тогтоож, ногдол ашиг хуваарилах ажлыг зохион байгуулах;

2.5.4 нийт гишүүд нь тухайн хэлцэлд ашиг сонирхлын зөрчилтэй байх, эсвэл тухайн хэлцэлд сонирхлын зөрчилгүй гишүүд дотор нь хараат бус гишүүд байхгүй бусад тохиолдолд сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах эсэхийг шийдэх;

Хамрах хүрээ: “Ди Би Эм ассет менежмент УЦК” ХХК	Журмын код:
Хариуцах эзэн: ТУЗ-ын Нарийн Бичгийн Дарга	Танилцах: ТУЗ, ТУЗНБД, Компанийн эрх бүхий этгээд
Баталсан огноо: 2022/04/21	Хуудас 6 /30

- 2.5.5 санхүү болон бизнесийн төлөвлөгөөнөөс гадна үйл ажиллагааг батлах шийдвэр гаргах (стандарт бус бизнесийн үйл ажиллагаа).
- 2.5.6 гадаад, дотоодын байгууллага, аж ахуйн нэгжтэй хөрөнгө оруулалтын харилцаанд хамтран ажиллах, хувьцаа гаргаж эзэмшигчлэх, хувь нийлүүлэн хөрөнгө оруулах замаар шинээр компани үүсгэн байгуулах саналыг хянаж, дүгнэлт гарган хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулах;
- 2.6 Компанийн гүйцэтгэх удирдлагыг чиглүүлэх, хянахтай холбоотой ТУЗ-ийн бүрэн эрх дараах үйл ажиллагааг хамарна. Үүнд:
- 2.6.1 ТУЗ-ийн дарга компанийг төлөөлөн гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн нарийн бичгийн даргатай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах эрх олгох;
- 2.6.2 компанийн гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн нарийн бичгийн ажлын хөлсийг оролцуулан хөдөлмөрийн гэрээний нөхцөлүүдийг тодорхойлох;
- 2.6.3 хөндлөнгийн аудитор томилох, түдгэлзүүлэх, түүнтэй байгуулах гэрээний нөхцөлүүдийг тодорхойлох;
- 2.6.4 улирлын санхүүгийн тайлан болон санхүүгийн Санхүүгийн зохицуулах хорооноос шаардан гаргуулж байгаа мэдээ тайланд үндэслэн хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль тогтоомжид болон хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгө оруулалтын бодлого журамд заасан нөхцөл шаардлагыг хэрхэн ханган ажиллаж байгаа талаар гүйцэтгэх захирлын тайланг улирал бүр хэлэлцэх, хэлэлцэж зөрчил, залруулах үйл ажиллагаа үүссэн бол түүний шалтгаан цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар шийдвэр гаргах;
- 2.6.5 компанийн эрх бүхий албан тушаалтнуудаас тодорхой асуудлаар мэдээлэл авах, тайлан, дүгнэлт гаргуулах, хэлэлцэх;
- 2.6.6 эрх бүхий албан тушаалтны компанийд болон удирдаж буй санд учруулсан хохирлын талаар шүүхэд нэхэмжлэл гаргах шийдвэр гаргах, төлөөлөх этгээдийг томилох;
- 2.6.7 компанийн ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар гүйцэтгэх захирлын эрх хэмжээнд хамаарахаас бусад асуудлыг шийдвэрлэх;
- 2.6.8 ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх;
- 2.7 Дээр дурьдсан асуудлаар шийдвэр гаргахаас гадна хяналтын тогтолцоо бүрдүүлэх талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
- 2.7.1 компанийн гүйцэтгэх албаны үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэлт дүгнэлт өгөх, удирдлагын үр ашигтай байдалд мониторинг хийх хяналтын тогтолцоо бүрдүүлэх;
- 2.7.2 Компанийн эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын тогтолцооны оновчтой байдал, санхүүгийн үйл ажиллагаа, үндсэн үйл ажиллагааны зардалд мониторинг хийх тогтолцоо бүрдүүлэх;
- 2.7.3 компанийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн үнэн зөв, бүрэн бүтэн байдлыг хангах, нягтлан бодох бүртгэл, аудитын олон улсын стандартыг нэвтрүүлэх ажиллагаанд хяналт тавих;
- 2.7.4 компани болон удирдаж буй сангийн мэдээллийг эрх бүхий этгээд хэрхэн хүргэж байгаа, нийтийн хүртээл болгохоор хууль болон дотоод дүрэм журмаар

Хамрах хүрээ: “Ди Би Эм ассет менежмент УЦК” ХХК	Журмын код:
Хариуцах эзэн: ТУЗ-ын Нарийн Бичгийн Дарга	Танилцах: ТУЗ, ТУЗНБД, Компанийн эрх бүхий этгээд
Баталсан огноо: 2022/04/21	Хуудас 7 /30

- тогтоосон мэдээллийг нээлттэй байлгах, үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж байгаад хяналт тавих;
- 2.7.5 компанийн хувьцаа эзэмшигчид болон удирдлагын хооронд, компани болон бусад оролцогчдын хооронд сонирхлын зөрчил үүссэн тохиолдолд компанийн эрх ашиг болон сайн засаглалын зарчимд нийцүүлэн шийдвэрлэх арга хэмжээ авах;
- 2.8 Хөрөнгө оруулалтын сангийн хууль тогтоомж, компанийн дотоод дүрэм журмаар тогтоосон хэм хэмжээг тасралтгүй дагаж мөрдүүлэх, санг төлбөрийн чадваргүй болохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах.
- 2.9 ТУЗ-ийн гишүүд нь компанийн гүйцэтгэх удирдлага, компанийн бүтэц, нэгжийн удирдлага нараас өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээлэл авах эрхтэй.
- 2.10 ТУЗ-ийн эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэгдээгүй асуудлуудыг гүйцэтгэх захиралд шилжүүлэхгүй.

ГУРАВ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- 3.1 Компанийн ТУЗ нь 3(гурван) гишүүнтэй бөгөөд тэдгээрийн 1(нэг) нь хараат бус гишүүн байна.
- 3.2 “МУ-ын Хөгжлийн банк”-наас 2(хоёр) этгээдийг ТУЗ-д нэр дэвшүүлнэ. ТУЗ-ийн хараат бус гишүүнийг нийтэд нээлттэй зарлах замаар нэр дэвшүүлэн сонгон шалгаруулна.
- 3.3 ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчид дараах шаардлага, шалгуурыг хангасан байх бөгөөд энэ нь төрийн байгууллагаас нэр дэвшигчдийн хувьд нэгэн адил хамаарна. Үүнд:
- 3.3.1 зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хугацаа хэтэрсэн аливаа өргүй;
 - 3.3.2 ял шийтгэлгүй;
 - 3.3.3 ёс зүйн болон бизнесийн нэр хүнд нь компанийг удирдахад харшлахгүй, хууль бус, ёс бус үйлдэлд нэр холбогдоогүй;
 - 3.3.4 санхүү, хөрөнгө оруулалт, эрх зүйн аль нэг чиглэлээр мэргэшсэн;
 - 3.3.5 санхүү, хөрөнгө оруулалтын салбарт таваас доошгүй жил удирдах албан тушаал хашсан;
 - 3.3.6 төрийн улс төрийн болон улс төрийн намын удирдах албан тушаал хашдаггүй;
 - 3.3.7 санхүү, хөрөнгө оруулалтын болон үнэт цаасны зах зээлд үйл ажиллагаа эрхэлдэг зохицуулалттай этгээд эрх бүхий албан тушаалтан биш;
 - 3.3.8 санхүү, хөрөнгө оруулалт, үнэт цаасны байгууллага болон тэдгээрийн холбогдох этгээдийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болон тэдгээрийн холбогдох этгээд биш;
 - 3.3.9 дампуурсан, төлбөрийн чадваргүй болсон хуулийн этгээдийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалд ажиллаж байгаагүй;
 - 3.3.10 өмнө нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуулиар тогтоосон хугацаанд хуралдуулаагүйгээс бүрэн эрх нь дуусгавар болсон компанийн ТУЗ-ийн гишүүн, эрх бүхий албан тушаалтан байгаагүй;

Хамрах хүрээ: “Ди Би Эм ассет менежмент УЦК” ХХК	Журмын код:
Хариуцах эзэн: ТУЗ-ын Нарийн Бичгийн Дарга	Танилцах: ТУЗ, ТУЗНБД, Компанийн эрх бүхий этгээд
Баталсан огноо: 2022/04/21	Хуудас 8 /30

- 3.3.11 Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон тохиромжтой этгээдийн шалгуурыг хангасан;
- 3.4 ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигч нь энэ журмын 3.3-т зааснаас гадна дараах шалгуур, шаардлагыг хангасан байна. Үүнд:
- 3.4.1 өөрөө эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь компанийн хувьцаа эзэмшигч биш;
 - 3.4.2 компанийн хяналтын багц хувьцаа эзэмшигчид, ТУЗ-ийн бусад гишүүн, гүйцэтгэх удирдлагын эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд биш;
 - 3.4.3 өөрөө эсхүл холбогдох этгээд нь компани оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогчийн эрх бүхий албан тушаалтан биш;
 - 3.4.4 төрийн үйлчилгээнийхээс бусад төрийн албан хаагч биш;
 - 3.4.5 компанийтай бизнесийн аливаа холбоогүй;
 - 3.4.6 Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлд заагдсан хязгаарлалтын шаардлагыг хангасан байх;
- 3.5 ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар ажиллаж байгаа хүнийг ТУЗ-ийн гишүүнээр сонгохгүй.

ДӨРӨВ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭН ЭРХИЙН ХУГАЦАА

- 4.1 ТУЗ-ийн бүрэн эрхийн хугацаа компанийн дүрмийн 9.4-т заасны дагуу байна.
- 4.2 ТУЗ-ийн сонгууль явуулах хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын өмнө Нэр дэвшүүлэх түр комисс нь ТУЗ-ийн гишүүн нэг бүрийн үйл ажиллагаанд энэ журмын дагуу үнэлэлт дүгнэлт өгөх бөгөөд энэ дүгнэлтээр “хангалтгүй” үнэлгээ авсан хүний нэрийг ТУЗ-д дахин дэвшүүлэхгүй. Дэвшүүлсэн тохиолдолд Нэр дэвшүүлэх түр комисс нь уг хүний нэрийг “Санал хураах хуудас”-нд оруулахгүй.
- 4.3 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Компанийн тухай хуульд заасны дагуу дараа жилийн 04 дүгээр сарын 30-ны дотор хуралдуулаагүй тохиолдолд ТУЗ-ийн ХЭХ-д бэлдэх, түүнийг зарлах зохион байгуулахаас бусад бүрэн эрх дуусгавар болно.
- 4.4 Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгож болно.
- 4.5 Хэрэв гишүүн нь удаан хугацаагаар үүргээ биелүүлэх боломжгүй болсон, ТУЗ-өөс чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан, нас барсан ТУЗ-ийн гишүүнийг орлох хүнийг дараагийн ХЭЭБХ хүргэл түр хугацаагаар ТУЗ өөрөө томилж болно.
- 4.6 ТУЗ-ийн гишүүдийн тоо нь ТУЗ нь компанийн дүрэм болон энэхүү журамд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон ТУЗ-ийн шинэ бүрэлдэхүүн, гишүүнийг сонгохор хувьцаа эзэмшигчдийн хурал ээлжит бус хурлыг зарлан хуралдуулна.

ТАВ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШҮҮЛЭХ, НЭР ДЭВШИГЧИЙГ ЖАГСААЛТАД БҮРТГЭХ, СОНГОХ ЖУРАМ

- 5.1 ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигчийг бүртгэх, энэхүү журмаар тогтоосон шаардлагыг хангаж байгаа эсэхийг хянах, нэр дэвшигчийг жагсаалтад бүртгэх эсэхийг шийдвэрлэх асуудлыг ТУЗ-ийн гишүүдийн дотроос сонгогдсон 1(нэг) түүнээс дээш гишүүн бүхий Нэр дэвшүүлэх түр комиссийг байгуулах бөгөөд комисс нь хариуцан хэрэгжүүлнэ.

Хамрах хүрээ: “Ди Би Эм ассет менежмент УЦК” ХХК	Журмын код:
Хариуцах эзэн: ТУЗ-ын Нарийн Бичгийн Дарга	Танилцах: ТУЗ, ТУЗНБД, Компанийн эрх бүхий этгээд
Баталсан огноо: 2022/04/21	Хуудас 9 /30

- 5.2 ТУЗ-ийн гишүүн нь, дэвшүүлж байгаа этгээд нь энэхүү журам, компанийн дүрмийг сайтар судалсан байх бөгөөд ТУЗ-ийн гишүүний хувьд үүргээ бүрэн биелүүлэх цаг, боломжтой эсэхээ сайтар тунгаан зөвшөөрлөө өгсөн байна.
- 5.3 ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэрийг нь дэвшүүлэх этгээдийг сонгохын тулд компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүнд тавих шалгуур, шаардлагыг заасан албан захицлыг Компанийн хувьцаа эзэмшигчийн нэрийн өмнөөс олон нийтэд мэдээлэл гарган нэр дэвших хүсэлтүүдийг хүлээн авах бөгөөд хүсэлт болон ирүүлсэн материалуудыг үзэж ирүүлсэн хүмүүсийн дотроос шалгуур шаардлага хангаж буй хамгийн тохиромжтой 3(гурав)-аас доошгүй хүний нэрийг санал хураах хуудсанд оруулна.
- 5.4 ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэхээр эрх бүхий этгээдээс ирүүлсэн санал, хавсаргасан баримтуудыг ТУЗ-ийн Нэр дэвшүүлэх түр комиссын нарийн бичгийн дарга хүлээн авч, бүрдлийг шалгаад бүрэн бүрдсэн бол хүлээн авсны дараах ажлын өдөр комиссын даргад танилцуулна. Комиссын дарга ирүүлсэн бичиг баримтад үндэслэн тухайн хүнийг нэр дэвшигчдийн жагсаалтад бүртгэх эсэх тухай санал, үндэслэлээ Нэр дэвшүүлэх түр комиссын хуралд ажлын 3(гурав) хоногийн дотор танилцуулна. Комиссын гишүүдийн олонхийн саналаар нэр дэвшигчийг жагсаалтад бүртгэх тухай шийдвэр гаргана. Тухайн нэр дэвшигчийг жагсаалтад бүртгэхээс татгалзсан тохиолдолд үндэслэлээ нэр дэвшүүлсэн этгээдэд бичгээр мэдэгдэнэ. Нэр дэвшүүлэгч нь нэр дэвшсэн этгээдийг жагсаалтад бүртгэхээс татгалзсан тохиолдолд Нэр дэвшигч нь үндэслэлгүй гэж үзвэл бичгээр мэдэгдэл хүлээн авснаас хойш ажлын 3(гурав) хоногийн дотор ТУЗ-ийн даргад гомдол гаргах эрхтэй.
- 5.5 ТУЗ-ийн дарга гомдлыг хүлээн авснаас хойш ажлын 5(таван) хоногт багтаан асуудлыг ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлээд шийдвэр гаргана. ТУЗ-ийн шийдвэр эцсийн шийдвэр байна.
- 5.6 Нэр дэвшигчийг жагсаалтад бүртгэхээс дараах үндэслэлээр татгалзаж болно. Үүнд:
- 5.6.1 нэр дэвшигч нь энэ журмын 3.3, 3.4 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй;
 - 5.6.2 нэр дэвшигчийн ирүүлсэн материал нь бүрдүүлэх материалын шаардлага хангаагүй;
 - 5.6.3 нэр дэвшигчийн ирүүлсэн мэдээлэл, баримт бичиг нь хуурамч нь тогтоогдсон;
- 5.7 ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн жагсаалтад бүртгэгдсэн хүний нэрийг хувьцаа эзэмшигчдийн хурлын санал авах хуудсанд оруулах бөгөөд энэхүү журмын 02-р хавсралтаар баталсан анкетыг хувьцаа эзэмшигчдийн хуралд зориулсан мэдээлэлд оруулсан байна.
- 5.8 ТУЗ-ийн гишүүдийг санал хураах энгийн аргаар сонгоно.
- 5.9 Ердийн гишүүнд нэр дэвшигчдээс хамгийн олон санал авсан эхний 2(хоёр) нэр дэвшигч ТУЗ-ийн ердийн гишүүнээр, хараат бус гишүүнд нэр дэвшигчдээс хамгийн олон санал авсан нэг нэр дэвшигч нь хараат бус гишүүнээр тус тус сонгоно.
- 5.10 Санал хураалтаар ТУЗ-ийн хараат бус 1 гишүүнийг сонгож чадаагүй бол ТУЗ нь бүрэн эрхээ хэрэгжүүлэх үүднээс даруй сонгон сонгон шалгаруулалтыг гүйцэтгэн эрх зүйн чадваргүйд тооогдох болно.
- 5.11 ТУЗ-д нэр дэвшигч жагсаалтад оруулахаас өмнө нэрээ татаж авах эрхтэй.

Хамрах хүрээ: “Ди Би Эм ассет менежмент УЦК” ХХК	Журмын код:
Хариуцах эзэн: ТУЗ-ын Нарийн Бичгийн Дарга	Танилцах: ТУЗ, ТУЗНБД, Компанийн эрх бүхий этгээд
Баталсан огноо: 2022/04/21	Хуудас 10 /30

ЗУРГАА. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

- 6.1 Компанийн ТУЗ-ийн гишүүд өөрсдийн дундаас олонхын санал авсан гишүүнийг ТУЗ-ийн даргаар сонгоно.
- 6.2 Компанийн гүйцэтгэх захирал, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүнээр ажиллаж байгаа нэр дэвшигчийг ТУЗ-ийн даргаар сонгохгүй.
- 6.3 ТУЗ-ийн зүгээс нийт сонгогдсон гишүүдийн олонхын санал авсан дүнгээр ТУЗ-ийн даргыг чөлөөлөх, дахин сонгох эрхтэй.
- 6.4 ТУЗ-ийн дарга дараах үйл ажиллагааг хариуцна:
- 6.4.1 ТУЗ-ийн ажлыг зохион байгуулах, нийт гишүүдийг санал бодлоо чөлөөтэй солилцох нөхцөлөөр хангах, хэлэлцэх асуудлуудаар нээлттэй хэлэлцүүлэг явуулах;
 - 6.4.2 ТУЗ-ийн уулзалтын хуваарь гаргаж, зохион байгуулах, хурлаар хэлэлцэх асуудлуудыг бэлтгэх, гишүүдийн зөвшөөрлийн бичигт үндэслэн санал хураалт явуулах;
 - 6.4.3 Хурлын тэмдэглэл хөтлүүлэх, тэмдэглэлд гарын үсэг зурах;
 - 6.4.4 Шаардлагатай тохиолдолд хурлын тэмдэглэлийг дүрс болон дуу бичлэг ашиглан хөтлөх, хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэнэ;
 - 6.4.5 Компанийг төлөөлөн гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээнд гарын үсэг зурах
 - 6.4.6 Хангалттай материалд үндэслэн зохистой хэлэлцүүлэг, санал хураалт явуулснаар ТУЗ-ийн хурлаар хэлэлцэх асуудлуудаар үр дүнтэй шийдвэр гаргах;
 - 6.4.7 Хурлаас долоо хоногоос доошгүй хугацааны өмнө гишүүдийг хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдох мэдээллээр хангах;
 - 6.4.8 ТУЗ-ийн хороог байгуулах ажлыг зохион байгуулах, тус хороонд гишүүдийг нэр дэвшүүлэх, компанийн ажилтан, гишүүд, хороодын хоорондын харилцааг зохицуулах;
 - 6.4.9 Гүйцэтгэх захирал болон бусад удирдах ажилтнуудтай байнгын харилцаа холбоотой ажиллах;
 - 6.4.10 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зохион байгуулах талаар хувьцаа эзэмшигчийн бичгээр гаргасан санал хүлээн авах;
- 6.5 Компанийн жилийн тайлан тусгах тухайн жилийн үйл ажиллагааны тайлан бэлтгэх.
- 6.6 ТУЗ-ийн даргыг байхгүй үед хуралд оролцож буй нийт гишүүдийн олонхын санал авсан шийдвэрийн дагуу томилогдсон эсвэл ТУЗ-ийн даргын томилсон гишүүн түүнийг орлоно.
- 6.7 ТУЗ-ийн дарга нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуулиар тогтоосон хугацаанд буюу жил бүрийн 04 дүгээр сарын 30-ний дотор хуралдуулж жилийн үйл ажиллагааны тайланг хэлэцүүлэх, хуралд “Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах журам”-д заасны дагуу хангалттай сайн бэлдэх асуудлыг биечлэн хянах онцгой үүрэг хүлээнэ.

Хамрах хүрээ: “Ди Би Эм ассет менежмент УЦК” ХХК	Журмын код:
Хариуцах эзэн: ТУЗ-ын Нарийн Бичгийн Дарга	Танилцах: ТУЗ, ТУЗНБД, Компанийн эрх бүхий этгээд
Баталсан огноо: 2022/04/21	Хуудас 11 /30

ДОЛОО. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛ

- 7.1 Шаардлагатай тохиолдолд ТУЗ-ийн хурлыг ТУЗ-ийн дарга өөрийн санаачилгаар улирал бүр нэг удаа зарлан хуралдуулах ба дараах албан тушаалтны саналын дагуу ээлжит бус хурлыг хуралдуулна. Үүнд:
- 7.1.1 ТУЗ-ийн гишүүн;
 - 7.1.2 Компанийн гүйцэтгэх захирал;
 - 7.1.3 Гэрээт аудит болон хөндлөнгийн аудитын байгууллага;
- 7.2 ТУЗ-ийн хурал хуралдуулах саналыг бичгээр үйлдэж компани руу баталгаат шуудангаар илгээх эсвэл компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн даргад хүргүүлнэ.
- 7.3 ТУЗ-ийн хурал хуралдуулах санал гаргасан огноог компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн даргын хүсэлт хүлээн авсан өдрөөр тодорхойлно.
- 7.4 ТУЗ-ийн хурлын хэлэлцэх асуудалд нэмэлт өөрчлөлт оруулах тохиолдолд хурал хуралдахаас хуанлийн 10(арав) хүртэл хоногийн өмнө ТУЗ-ийн гишүүд нэмэлт өөрчлөлтийн саналаа ТУЗ-ийн Нарийн бичгийн даргад хүргүүлж болно.
- 7.5 Хурал хуралдуулах санал гаргасан хүн нэр албан тушаалаа дурьдан тухайн саналдаа гарын үсэг зурсан байна.
- 7.6 Саналд дараах зүйлүүдийг дурдана. Үүнд:
- 7.6.1 Хурал хуралдуулах санал гаргасан хүний нэр;
 - 7.6.2 Хэлэлцэх асуудлууд;
 - 7.6.3 хэлэлцүүлэхээр санал болгож буй асуудал, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээлэл, өөрт нь байгаа мэдээлэл шийдвэр гаргахад хангалттай бус гэж үзэж байгаа бол ямар мэдээллийг хэрхэн толилуулах талаарх санал;
- 7.7 ТУЗ-ийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах тов бүхий шаардлагыг ийнхүү хурал хуралдуулахаар санал болгож буй өдрөөс хуанлийн 14(арван)-өөс доошгүй хоногийн өмнө ТУЗ-ийн Нарийн бичгийн даргад хүргүүлнэ.
- 7.8 ТУЗ-ийн дарга хурал зарлахаас үндэслэлгүйгээр татгалзсан эсвэл хүндэтгэн үзэх шалтгааны улмаас үүргээ гүйцэтгэх боломжгүй бол, ТУЗ-ийн бусад гишүүн тус хурлыг зарлаж болно.
- 7.9 ТУЗ-ийн хурал болох огноо, газар, эхлэх цаг, хэлэлцэх асуудлын талаарх мэдэгдэл, хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой болон хуралд бэлтгэхэд шаардлагатай мэдээллийг ТУЗ-ийн гишүүн тус бүрт болон энэ дурмийн 8.1-т заасан хурал хуралдуулах санал гаргасан этгээдэд баталгаат шуудангаар эсвэл биечлэн хүргэх ба хурал болохос тав (5)-аас доошгүй өдрийн өмнө мэдэгдэнэ.
- 7.10 ТУЗ-ийн анхны хурлыг ТУЗ-ийн гишүүд сонгогдсноос хойш 10(арав) хоногийн дотор хуралдуулхыг эрмэлзэнэ.
- 7.11 Хуралд ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонх (2/3) биеэр, саналын хуудсаар, утсаар болон цахимаар оролцсон тохиолдолд хүчин төгөлдөр болох ирц бүрдэнэ.
- 7.12 Хуралд санал өгөх эрхээ бусад гишүүнд болон өөр этгээдэд итгэмжлэх замаар хэрэгжүүлэхийг хориглоно.
- 7.13 ТУЗ-ийн хурлын шийдвэр нь хуралд оролцсон гишүүдийн дийлэнх олонхийн (2/3) саналаар хүчин төгөлдөр болох бөгөөд шийдвэр нь тогтоол хэлбэртэй байна. Тогтоолд хурал даргалсан ТУЗ-ийн гишүүн гарын үсэг зурж баталгаажуулна.

Хамрах хүрээ: “Ди Би Эм ассет менежмент УЦК” ХХК	Журмын код:
Хариуцах эзэн: ТУЗ-ын Нарийн Бичгийн Дарга	Танилцах: ТУЗ, ТУЗНБД, Компанийн эрх бүхий этгээд
Баталсан огноо: 2022/04/21	Хуудас 12 /30

- 7.14 Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх асуудлыг шийдвэрлэж байгаа бол уг хэлцлээс ямар нэг хэлбэрээр орлого хүргэх боломжтой эсхүл өөрөө болон холбогдох этгээд нь хэлцлийн нөгөө тал болж байгаа, эсхүл хэлцэл зуучлагч, төлөөлөгчөөр оролцож байгаа ТУЗ-ийн гишүүн уг асуудлаар болон хэлцлийн зүйлийн үнийг тогтоох асуудлаар санал өгөх эрхгүй байна. Энэ тохиолдолд шийдвэрийг саналын эрхтэй гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ. Санал тэнцсэн тохиолдолд шийдвэрийг ТУЗ-ийн даргын саналаар гаргана.
- 7.15 ТУЗ нь тодорхой 2(хоёр)-оос илүүгүй асуудлаар эчнээ санал хураалт явуулах замаар шийдвэр гаргаж болно. Энэ тохиолдолд шийдвэрлэх асуудлын томьёолол, түүнтэй холбогдох бүрэн мэдээлэл, танилцуулгыг ТУЗ-ийн гишүүдэд бичгээр /цаасаар юмуу цахим шуудангаар/ хүргүүлэх бөгөөд хүргүүлснээс хойш 5(тав)-аас доошгүй хоногийн дараа ТУЗ-ийн гишүүдийн саналыг авахаар заасан байна. Эчнээ санал хураалтаар шийдвэрлэх асуудлаар ТУЗ-ийн гишүүд бичгээр /цаасаар юмуу цахим шуудангаар/ саналаа ирүүлэх бөгөөд ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонх нь саналаа ирүүлсэн, тэдгээрийн дийлэнх олонх нь уг асуудлаар гарах шийдвэрийн төслийг зөвшөөрсөн бол эчнээ санал хураалтаар тухайн асуудлыг шийдвэрлэсэнд тооцож, ТУЗ-ийн тогтоол гарган, ТУЗ-ийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна. ТУЗ-ийн гишүүд эчнээ санал хураалтаар гаргасан шийдвэрийн албажуулсан хувьтай танилцах эрхтэй.

НАЙМ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

- 8.1 ТУЗ-ийн нарийн бичгийн дарга ТУЗ-ийн хурлын тэмдэглэлийг хөтөлнө.
- 8.2 ТУЗ-ийн хурлын тэмдэглэлийг хурал дууссанаас хойш 3(гурван) өдрийн дотор үйлдэнэ. Хурлын тэмдэглэл дараах мэдээллийн бүрдэнэ. Үүнд:
- 8.2.1 Компанийн албан ёсны нэр ба хаяг;
 - 8.2.2 Хурал болох газар (хаяг), эхлэх цаг;
 - 8.2.3 Хурлын хэлэлцэх асуудал;
 - 8.2.4 Хуралд оролцож байгаа оролцогчид болон хурлын ирцийн тоо;
 - 8.2.5 Хуралд биечлэн оролцоогүй боловч бичгээр саналаа өгсөн гишүүд;
 - 8.2.6 Санал хураасан асуудлууд, санал хураалтын дүн;
 - 8.2.7 Гаргасан шийдвэрүүд;
 - 8.2.8 Тухайн хэлэлцсэн асуудлын хүрээнд эсрэг саналтай байсан гишүүдийн нэр, эсрэг саналын үндэслэл, тайлбар;
- 8.3 ТУЗ-ийн хурлын тэмдэглэл дээр тэмдэглэлийн үнэн зөвийг хариуцсан ТУЗ-ийн дарга, хуралд оролцсон нийт гишүүд, компанийн ТУЗ-ийн нарийн бичиг гарын үсэг зурна.
- 8.4 Гишүүдийн бичгээр гаргасан саналуудыг тэмдэглэлд хавсаргана.
- 8.5 Саналын хуудсаар хураасан санал, саналын дүнгийн талаар тэмдэглэлийг саналын хуудас хүлээн авах эцсийн өдрөөс хойш 3 (гурван) хоногийн үйлдэх ба тэмдэглэлд ТУЗ-ийн дарга, нарийн бичиг гарын үсэг зурна. Тэмдэглэлд дараах мэдээллийг багтаана. Үүнд:
- 8.5.1 Саналын хуудсаар санал хураасан асуудлууд;
 - 8.5.2 Асуудал тус бүрт гаргасан шийдвэрийн тайлбар;
 - 8.5.3 Асуудал тус бүрийн санал хураалтын дүн.

ЭНЭХҮҮ ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГИЙГ “ДИ БИ ЭМ АССЕТ МЕНЕЖМЕНТ УЦК” ХХКОМПАНИЙН ЗӨВШӨӨРӨЛГҮЙГЭЭР АШИГЛАХ, ТҮГЭЭХ, ТАРААХ, НИЙТИЙН ХҮРТЭЭЛ БОЛГОХЫГ ХОРИГЛОНО.

Хамрах хүрээ: “Ди Би Эм ассет менежмент УЦК” ХХК	Журмын код:
Хариуцах эзэн: ТУЗ-ын Нарийн Бичгийн Дарга	Танилцах: ТУЗ, ТУЗНБД, Компанийн эрх бүхий этгээд
Баталсан огноо: 2022/04/21	Хуудас 13 /30

- 8.6 Компани ТУЗ-ийн хурлын тэмдэглэлийг компанийн байрандаа хадгална.
- 8.7 ТУЗ-ын хурлын тэмдэглэлийг буруу буюу уг үсгийн найруулгын алдаатай хөтөлсөн нь уг хурлын шийдвэрийг хүчингүйд тооцох үндэслэл болохгүй бөгөөд уг алдаа илэрсэн даруй засварлана.

ЕС. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

- 9.1 Гишүүдийн эрх, үүргээ дараах байдлаар хэрэгжүүлнэ. Үүнд:
- 9.1.1 Шийдвэр гаргахдаа ул суурьтай, үнэнч шударга хандаж, компани болон хувьцаа эзэмшигчдийн язгуур эрх ашгийн төлөө ажиллана. Өөрөөр хэлбэл бүх боломжит мэдээллийг анхаарч үзэх, ойролцоо нөхцөл байдалд анхааралтай, сайтар бодож боловсруулсан шийдвэр гаргах;
 - 9.1.2 ТУЗ-ийн болон ТУЗ-ийн хороодын хуралдаанд биеэр эсхүл хэлэлцэх асуудал бүрт тодорхой санал тайлбартай бичгээр саналаа өгөх замаар оролцоно. Гадаадад болон орон нутагт ажиллаж байгаа, амралттай байгаа тохиолдолд ч хурлын материалыг цахим шуудангаар хүлээн авч дэлгэрэнгүй санал, тайлбартай хариу өгөх юмуу хуралдааны явцад утсаар саналаа өгөх, бусад техник хэрэгсэл ашиглан интернетээр санал солилцох замаар оролцох ёстай. Боломжтой тохиолдолд биеэр оролцохыг анхаарна. Учир нь хурлаар урьдчилан товлоогүй “чухал” асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх шаардлага тулгарах тохиолдол байна.
 - 9.1.3 Зарлагдсан хурлуудад оролцох, сонгогдсон ТУЗ-ийн хорооны ажилд оролцох;
 - 9.1.4 Тодорхой бус, ойлгомжгүй асуудлуудын талаар тодруулга хийж, асуулт тавих;
 - 9.1.5 ТУЗ-ийн хуралд оролцох боломжгүй болсон тохиолдолд оролцох боломжгүй болсон хүндэтгэн үзэх шалтгаанаа ТУЗ-д урьдчилан мэдэгдэнэ;
- 9.2 ТУЗ-ийн гишүүн нь өөрийн цахим шуудангийн хаягийг ТУЗ-ийн нарийн бичгийн даргад албан ёсоор мэдэгдэж, хүргүүлсэн мэдээллийг бүртгүүлсэн хаягаараа тогтмол хүлээн авч, хариу өгдөг байна. Тодорхой бус ойлгомжгүй асуудлын талаар лавлагаа, тодруулгыг тухай бүр авч байна.
- 9.3 Дараах ашиг, сонирхлын зөрчилдөөний дүрэм, журмын дагуу ажиллана. Үүнд:
- 9.3.1 Гишүүнээр ажиллаж буй компани болон түүний салбар компанийн үнэт цаастай холбоотой үйл ажиллагаанд оролцох зорилго гэх мэт компанийн үйл ажиллагаа, гэрээ, төсөлд хувийн арилжаа, ашиг сонирхлын улмаас (шууд болон шууд бус) оролцох бол энэ талаар ТУЗ-ийн даргад нэн даруй бичгээр мэдэгдэх ба үнэт цаастай холбоотой үйл ажиллагааны талаар мэдээллэнэ;
